



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарви сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Н.Батзул Утас: 98111917 Цахим хаяг: batzuln@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	9
3.2 Албан шаардлага.....	10
3.3 Зөвлөмж:	10
4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

КХБ-03.26 № 280

танай _____ -ны № _____ -т

ДАРВИ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ж.Б.ХАЙДАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дарви сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Дарви сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.1, 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 24 дүгээр зүйлийн 24.6, 29 дүгээр зүйлийн 29.4, 60 дугаар зүйлийн 60.3.1, 60.3.68, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 10.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажилд хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс ажлын тоо хэмжээнээс 27,529.2 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгө дутуу нийлүүлэгдсэн;
- ✓ Хөрөнгө оруулалтын ажлын гэрээнд тусгасан чанарын барьцаа болох 1,940.0 мянган төгрөгийг суутган аваагүй, санхүүжилтийг бүрэн олгосон;
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ нийлүүлэхээр худалдан авах ажиллагааны үр дүнд шалгарсан аж ахуйн нэгжүүдэд гүйцэтгэлд үндэслэхгүйгээр 167,441.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон;
- ✓ Ахлах, дунд ангийн хүүхдийн үдийн хоол хөтөлбөрийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж 87,218.3 мянган төгрөгийг зарцуулсан ч анхан шатны баримт дутуу;

8426110693

- ✓ Хоршоо хөгжүүлэх сангийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүйгээс хугацаа хэтэрсэн 61,269.2 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг хуулийн байгууллагад шилжүүлээгүй;
- ✓ Тайлант онд зээл авсан иргэдийн зээлийн хүүг төлүүлээгүй, гэрээнд алданги тооцох талаар заалт оруулаагүй;

Асуудлыг онцолсон хэсэг

Дарви сум нь 2025 оны байдлаар 4,470 хүн амтай, 1060 өрхтэй, жилийн эцсийн мал тооллогоор 231,874 толгой мал тоолуулан, 110 аж ахуйн нэгж тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дарви сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 3,215,131.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 398,951.2 мянган төгрөг буюу 14.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Тайлант онд дээд шатны төсөвт 1,066,355.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн бол давсан орлогоос 317,147.4 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

Бусад асуудлын хэсэг

Сумын Засаг даргын 2025 оны дэвшүүлсэн зорилт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга үнэлж шилдэг сумаар шалгаруулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

№	Дансны нэр, төрөл	(мян.төгрөгөөр)	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,575,635.45	2,075,031.06
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,093,058.56	1,243,588.6
3	1.1.3 АВЛАГА	1,376,091.01	709,199.58
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	106,485.88	122,242.88
5	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,299,765.27	5,116,660.43
6	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,299,765.27	5,116,660.43
7	1.2.2.02 Биет хөрөнгө	4,268,787.77	5,086,361.68
8	1.2.2.03 Биет бус хөрөнгө	30,977.5	30,298.75
9	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	7,875,400.72	7,191,691.48
10	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	106,507.95	276,534.44
11	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	106,507.95	276,534.44
12	2.1.1.03 Өглөг	106,507.95	276,534.44
13	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,768,892.76	6,915,157.05
14	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	7,768,892.76	6,915,157.05
15	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	662,858.9	662,858.9
16	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	6,787,352.16	5,933,616.44
17	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	318,681.71	318,681.71
18	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	7,875,400.72	7,191,691.48

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Дансны нэр, төрөл	(мян.төгрөгөөр)	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	7,781,830.94	6,418,972.33
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	3,001,815.44	2,999,291.83
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	2,330,442.03	2,366,687.82
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	2,355,011.91	2,386,965.99
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-24,569.87	-20,278.17
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	125,522.4	128,733.22
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	545,851	503,870.8
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,239,599.19	3,419,680.49
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	18,991.71
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,540,416.32	0.0
11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,952,225.49	7,266,337.57
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	5,952,225.49	7,266,337.57
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,013,881.41	5,858,965.08
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	791,807.33	935,727.47
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,875.71	115,343.49
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	483,676.16	508,090.27
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	2,157,908.3	3,448,181.96
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.0	262.1
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	13,649.08	17,639.6
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	12,018	16,108.1
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	339,795.11	204,655.41

22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	1,121,151.71	612,956.69
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	938,344.08	1,407,372.49
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,829,605.46	-847,365.24
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	150	6,370.48
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-150	-6,370.48
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	1,829,455.46	-853,735.72

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Дансны нэр, төрөл	(мян.төгрөгөөр)	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	6,353,718.06	5,034,245.49
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	3,001,815.44	2,999,291.83
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	2,330,442.03	2,366,687.82
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-24,569.87	-20,278.17
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	125,522.4	128,733.22
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	545,851	503,870.8
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	11,227.6	4,515.81
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	531,981.32	496,555
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,642.08	2,800
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,800,303.66	2,034,953.65
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,800,303.66	1,529,100.08
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	94,624.37
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	411,229.2
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,551,598.96	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,453,725.27	3,455,299.09
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	3,453,725.27	3,455,299.09
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,514,313.27	2,047,813.4
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	839,428.82	1,017,526.37
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,547.46	114,492.3
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	500,256.01	521,812.04
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	47,039.88	50,704.34
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	853.7	358
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	15,996.3	17,803.6
24	1.1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	11,526.7	14,878.1
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	414,351.47	203,267.85
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	582,312.94	106,970.8
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	939,412	1,407,485.69
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,899,992.79	1,578,946.4
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	2,831,528.27	2,368,266.36
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,831,528.27	2,368,266.36
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	2,831,528.27	2,368,266.36
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,831,528.27	-2,368,266.36
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150	60,150
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-150	-60,150
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	68,314.52	-849,469.96
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,024,744.04	2,093,058.56
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,093,058.56	1,243,588.6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Дансны нэр, төрөл	(мян.төгрөгөөр)	
		Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,939,437.31	5,939,437.31
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,939,437.31	5,939,437.31
3	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,829,455.46	1,829,455.46
4	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,768,892.76	7,768,892.76
5	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,768,892.76	7,768,892.76
6	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,768,892.76	7,768,892.76
7	1.7 Тайлант үеийн үр дүн	-853,735.72	-853,735.72
8	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,915,157.05	6,915,157.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	(мян.төгрөгөөр)	
		1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,205,709.3	4,774,870.0
11	3.1.01.1.1 Татварын орлого	2,814,575.1	2,999,291.8
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	2,364,721.8	2,366,687.8
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	2,385,000.0	2,386,966.0
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	2,215,500.00	2,216,861.10
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	23,000.00	31,447.80
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	80,000.00	73,071.40
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	-	-
110008	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	66,500.00	65,585.70
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,278.2)	(20,278.2)
110101	3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(20,278.20)	(20,278.20)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	122,550.0	128,733.2
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	70,000.00	68,335.00
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	2,550.00	2,596.00
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	50,000.00	57,802.20
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	327,303.3	503,870.8
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,700.0	4,515.8
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	314,103.3	496,555.0
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	314,103.30	

1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,500.0	2,800.0
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,391,134.2	1,775,578.2
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	979,905.0	1,364,349.0
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	978,300.00	1,148,509.50
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	411,229.2	411,229.2
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,854,519.9	5,567,928.8
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,872,790.7	3,139,512.4
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,781,962.0	1,732,026.7
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	940,044.3	933,364.3
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,200.2	114,492.3
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	510,029.1	508,390.2
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	36,148.4	28,864.7
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.2	358.0
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	21,962.9	17,803.6
2107	3.1.01.2.1.1.7 Томилт, зочны зардал	20,714.7	14,878.1
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,489.8	92,218.5
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	23,689.4	21,657.0
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,090,828.7	1,407,485.7
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,921,729.2	2,368,266.4
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	60,000.0	60,150.0
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,648,810.6	(793,058.8)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,005,708.3
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,212,649.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	(мян.төгрөгөөр)	
		2024.12.31	2025.12.31
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	907,852.9	94,624.3
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	907,852.9	94,624.3
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	907,852.9	94,624.3
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	907,852.9	94,624.3
	1.1.1.1.1.1.1.2 төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		21,340.0

350013	1.1.1.1.1.1.3 ЗГНХ.ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захиргачид хувиарласан хөрөнгө		12,677.8
350011	1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	907,852.9	1,209.2
350015	1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		59,397.3
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	832,220.3	63,738.0
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ		63,738.0
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		792.0
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	4,279.9	792.0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294,954.4	53,264.9
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	521,223.4	9,681.1
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	6,600.0	0.0
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	5,162.6	0.0
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	75,632.6	30,886.3

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 540,823.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 194,853.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- Татаас санхүүжилтийн авлагыг 194,853.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 345,970.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 29,469.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 167,441.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж 149,059.7 мянган төгрөгийн 4 заалт бүхий зөвлөмж бичлээ.

Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

3.1.1 ОНХС-гийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт /тоног төхөөрөмж суурилуулах/ ажлын гүйцэтгэлд хийсэн шалгалтаар ажлын тоо хэмжээнээс алсын харагч 2 кабин, нисдэг сандал 12ш дутуу, ажлын тоо хэмжээ зөрүүтэй 27,529.2 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтад Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

журмын 4 дүгээр зүйлийн 4.9.2-д “Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацаанд Барилгын тухай хуулийн 14.6-д, авто замын байгууламжийн тухайд Авто замын тухай хуулийн 28.4-т заасан хугацааг тус тус баримтлах бөгөөд баталгаат хугацаанд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлуулж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоосон.

3.1.2 ОНХС-гийн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хөрөнгө оруулалтын ажлын гэрээнд тусгасан чанарын баталгааны 5 хувь болох 1,940.0 мянган төгрөгийг суутган аваагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5-д “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

3.2.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ нийлүүлэхээр шалгарсан аж ахуйн нэгжүүдэд аж ахуйн нэгжүүдэд гүйцэтгэлд үндэслэхгүйгээр 167,441.1 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”; ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43.1-т “Тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу баталгаа гаргасан бол ажлын бэлтгэл хангахад зориулан гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлнө”, 43.3-т “Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно” гэж заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж:

3.3.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ахлах, дунд ангийн үдийн хоолны зарцуулалтын анхан шатны баримт дутуу байхад 87,218.3 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөгжлийн сангаас батлан хэрэгжүүлж байгаа хүүхдийн хоолны зардлыг сумын сургуульд шилжүүлэн олгож, зарцуулалтын хяналтыг сургууль нэгтгэн хяналт хэрэгжүүлж ажиллах

3.3.2 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал:

3.3.2.1 Илрүүлэлт: Хугацаа хэтэрсэн 61,269.2 мянган төгрөгийн зээлийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байгаа нь Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 10.4-т “Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй

зээлдэгчийн ангилалд бүртгэнэ" 10.1-т "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллах

3.3.2.2 Илрүүлэлт: Тайлант онд шинээр гаргасан 4 зээлдэгчийн хүүгийн төлбөрийг төлүүлээгүй, гэрээнд алданги тооцох хувь заагаагүй байгаа нь Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 10.4-т "Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ" 10.1-т "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зээлдэгч нартай гэрээг шинэчлэн байгуулж журамд заасны дагуу алдангийн хэмжээг оруулах.

3.3.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд сумын ТТЗ нь нийт мэдээлбэл зохих 181 мэдээллээс 160 мэдээллийг хугацаандаа, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй, 7 мэдээллийг байршуулаагүй байна. Байгууллагын батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр зориулалт, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.1.2-д "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор" гэж заасантай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ТТЗ	Авлагыг санхүүгийн тайланд дутуу илэрхийлсэн	1	194,853.6	1	194,853.6			1	194,853.6				
ДҮН		1	194,853.6	1	194,853.6			1	194,853.6		0	0	0

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ОНХС	Ажлын тоо хэмжээнээс дутуу нийлүүлсэн	1	27,529.3	1	27,529.3						
	Барьцаа суутган аваагүй	1	1,940.0	1	1,940.0						
	Гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй, урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр урьдчилгаа олгосон	1	167,441.1			1	167,441.1				
	Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн	1	87,219.3					1	87,219.3		
ХХС	Хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй	1	61,269.2					1	61,269.2		
	Зээлийн гэрээнд алдангийн хэмжээг тусгаагүй	1	571.2					1	571.2		
Нийт дүн		6	345,970.1	2	29,469.3	1	167,441.1	3	149,059.7		

3.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
ТТЗ	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй	1	-					1	0
Нийт дүн		1	0					1	0

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1	0	0	0	1	0	0
	НИЙТ	1	1	0	0	0	1	0	0

